



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУНДАЛ

2015 оны 02 сарын 06

Дугаар А/14

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.12.14 заалт, Эрдмийн зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинжлэх ухаан технологийн их сургуульд судалгааны профессорын баг байгуулж, ажиллуулах түр журам”-ыг хавсралтаар баталж, 2014/2015 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн мөрдсүгэй.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэм шинжилгээ технологийн проректор /Ч.Баасандаш/, Сургалтын проректор /Х.Энхжаргал/, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн захирал наарт даалгасугай.

РЕКТОР

Б.ОЧИРБАТ

## ШУТИС-Д СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГ БАЙГУУЛЖ, АЖИЛЛУУЛАХ ТҮР ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. ШУТИС-ийн Судалгааны профессорын баг (цаашид СПБ гэх) нь сургалт-судалгаа-үйлдвэрлэлийг нягт уялдуулах замаар шинжлэх ухааны үндэслэлтэй шинэ мэдлэг бий болгохуйц эрдэм судлалыг хөгжүүлэх, мэдлэг, технологи дамжуулан хэрэглээний эргэлтэнд оруулахад чиглэсэн инновацийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах, улмаар энтрепренер хэв шинж бүхий судалгаанд суурилсан их сургууль болох ШУТИС-ийн хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх, Монгол Улсад мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, тэргүүлэх чиглэлүүдээр судалгааны ажил эрхлэх үндсэн зорилготой эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн нэгж байна.
- 1.2. СПБ-ийн үйл ажиллагаа нь их сургуулийн хэмжээнд инновацийн соёлыг төлөвшүүлэх замаар хамтын ажиллагаа, түншлэлийг шинэ шатанд гаргаж, эрдэмтэн, судлаачдын академик эрх чөлөөг хангах, инновацийн дэд бүтцийг бүрдүүлж, старт-ап бизнес болон энтрепренер хэв шинжийг хөгжүүлэхэд чиглэнэ.
- 1.3. Энэхүү журам нь Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Инновацийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, ШУТИС-ийн хөгжлийн бодлого, үзэл баримтлал, холбогдох дүрэм журмыг үндэслэн ШУТИС-д СПБ байгуулж, ажиллуулах үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

### ХОЁР. СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГ БАЙГУУЛАХ

- 2.1. Судалгааны чиглэлийн хувьд нэгдсэн зорилготой профессор, судлаач, багш нар СПБ баг байгуулах хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн холбогдох салбар болон Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ШУТИС-ийн Ректорын зөвлөлд уламжилна.
- 2.2. СПБ байгуулахад шаардлагатай материалыг хавсралтын дагуу бүрдүүлнэ. Хавсралтын маягтыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай Эрдэм шинжилгээ, инновацийн дэд зөвлөлийн саналыг үндэслэн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.
- 2.3. Бүрэлдэхүүн сургуулийн профессор, багш нар салбар дундын хамтарсан судалгааны профессорын баг байгуулан ажиллаж болно.
- 2.4. ШУТИС-ийн Ректорын зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөс ирүүлсэн санал, судалгааны чиглэлийг үндэслэн СПБ байгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх ба ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 2.5. СПБ-ийг судалгааны чиглэл, гишүүдийн харьяаллыг харгалзан холбогдох бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнг түшиглэн 2 жил хүртэл хугацаагаар

- байгуулах бөгөөд ажлын үр дүнг харгалзан нэг удаа хугацааг сунган ажиллуулж болно.
- 2.6. СПБ-ийн ахлагч профессор болон багийн гишүүдийн бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар баталгаажуулна.
  - 2.7. Их сургуулийн хэмжээнд тухайн судалгааны чиглэлээр нэг СПБ ажиллах бөгөөд давхардсан тохиолдолд нээлттэй шалгаруулалтын зарчмыг баримтлан ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 3.1. Судалгааны онол, арга зүйн түвшинг тасралтгүй дээшлүүлж, улсын болон их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлүүдээр судалгааг өндөр түвшинд явуулах, гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 3.2. Судалгаа, туршилт, шинэ бүтээлийн үр дүнгээр эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэх, оюуны өмчийн баталгаажуулалт хийлгэх;
- 3.3. Зах зээлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан шинэ технологийн судалгаа хийх, шинжлэх ухаан, технологийн ололтыг нутагшуулахад чиглэсэн инновацийн үйл ажиллагаа явуулах;
- 3.4. Судалгааны материалаг баазыг бэхжүүлж, инновацийн дэд бүтцийг бүрдүүлэх;
- 3.5. Судалгаа, инновацийн үйл ажиллагааны үр дүнг нийтэд сурталчлах, судалгааны чиглэлийн дагуу бүх шатны эрдэм шинжилгээний хурал, семинар, симпозиум, үзэсгэлэн зохион байгуулах, оролцох;
- 3.6. Судалгаа, үйлдвэрлэлийн хүрээнд хамтын ажиллагаа, инновацийн түншлэлийг хөгжүүлэх;
- 3.7. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, экспертиз хийх;
- 3.8. Магистр, докторын зэрэг олгох болон мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагаанд оролцож сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэн, сургалт, судалгааны ажлын нэгдлийг хангах;
- 3.9. СПБ-ийн судалгааны чиглэл, хэрэгжүүлж буй төслийн хүрээнд элсүүлэх боломжтой магистр, доктор оюутны судалгааны сэдэв, элсэлтийн тооны саналыг холбогдох нэгжид гаргаж өгөх;
- 3.10. Магистр, доктор оюутны судалгааны ажлын сэдэв агуулгыг хэлэлцэж батлах, судалгааны явцыг дүгнэж, урьдчилсан хэлэлцүүлэг хийх;
- 3.11. Судалгааны төслүүд дээр ажиллаж байгаа магистр, доктор оюутанд тэтгэлэг олгох;
- 3.12. СПБ-ийн гишүүд нь сургалтын үйл ажиллагаанд оролцож, албан тушаалын ангиллаар ногдол кредитийг биелүүлэх;
  - 3.12.1. СПБ-ийн гишүүн нь хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд сургалтын ногдол кредит цагийг өөрийн харьялагдах салбар, тэнхимиийн эрхлэгчийн шийдвэр, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
  - 3.12.2. СПБ-ийн гишүүний үндсэн харьялагдах салбар, тэнхимдээ гүйцэтгэх сургалтын кредит цагийн ногдол нь албан тушаалын үндсэн ногдолын 25-иас багагүй байна.
  - 3.12.3. Салбар, тэнхимиийн эрхлэгч нь СПБ-т давхар ажиллаж буй профессор, багш нарын сургалтын чанар, ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллана.

- 3.13. СПБ-ийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, ажлын явц, үр дүнг хэлэлцэх, хамтын шийдвэр гаргах, профессор, багш, судлаач, бүх шатны суралцагчдыг судалгааны арга барилд сургах, эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын үр дүн, чанарыг дээшлүүлэх, хамтарсан судалгааны ажлыг өргөжүүлэх зорилготой багийн семинарыг зохион байгуулах;
  - 3.13.1. Семинар нь багийн болон нээлттэй гэсэн хэлбэртэй байна.
  - 3.13.2. Багийн семинарыг хоёр долоо хоногт 1 удаа тогтмол зохион байгуулна.
  - 3.13.3. Нээлттэй семинарыг мэргэжил хоорондын уялдааг бэхжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор бусад сургалт, судалгааны байгууллагуудтай хамтран улиралд 1-2 удаа зохион байгуулна.
  - 3.13.4. Профессор нь семинарт оролцогч бүртэй мэдээллийн нууцлалын гэрээг хуулийн хүрээнд байгуулж ажиллана.

## ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГИЙН БҮТЭЦ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1. СПБ нь бүрэлдэхүүндээ профессор, дэд профессор, гүйцэтгэх профессор (докторын зэрэгтэй ахлах багш), гадаад, дотоодын зочин буюу урилгын профессор (Visiting professor), судлаач, гэрээт профессор (Adjunct professor), зөвлөх профессор (Emeritus professor), судлаач, инженер, бусад бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвийн профессор, багш, эрдэм шинжилгээний ажилтныг судлаачаар ажиллуулж болно.
- 4.2. Тухайн СПБ-т туршилт судалгааны ажил гүйцэтгэж байгаа бакалаврын төгсөх ангийн болон магистр, доктор оюутан, мэргэжил дээшлүүлэгчдээс бурдсэн судалгааны туслах багийг ажиллуулж болно.
- 4.3. СПБ-ийн үйл ажиллагааг удирдах профессор дараах шаардлагыг хангасан байна.
  - 4.3.1. СПБ-ийн судалгааны чиглэлийг удирдах, орлого бүрдүүлэх, судалгааны бааз, инновацийн нөөцийг бүрэн удирдаж, экосистемийг шинээр бий болгох чиглэлд үйл ажиллагаа явуулах чадвартай;
  - 4.3.2. Багийн гишүүдийг удирдан зохион байгуулах, манлайлах, тэдний энтерпренер чадавхийг удирдан чиглүүлэх, хамтран ажиллах чадвартай;
  - 4.3.3. Доктор(Ph.D)-оос доошгүй зэрэгтэй, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан туршлагатай;
  - 4.3.4. Дотоод, гадаадын эрдэмтэдтэй хамтарсан эрдэм шинжилгээний төсөл, судалгааны ажил гүйцэтгэсэн туршлагатай, тодорхой тооны бүтээлтэй
- 4.4. Профессорын эрх:
  - 4.4.1. Тэндер, төсөл, гэрээт ажлын сонгон шалгаруулалтад оролцохдоо бусадтай түншлэлийн гэрээ байгуулах, хамтран ажиллах асуудлыг бие даан шийдвэрлэх;
  - 4.4.2. Туслах багийн бүтцэд ажиллах гишүүдийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах гэрээ байгуулах ба гэрээнд гүйцэтгүүлэх ажлын хэмжээ болон судалгааны ажлын санхүүжилтээс тэднийг цалинжуулах, тэтгэлэг олгох асуудлыг тусгах;
  - 4.4.3. Судалгааны лаборатори байгуулах, шинэчлэх, өөрчлөх;

- 4.4.4. Бүрэлдэхүүн сургуультай байгуулсан гэрээний дагуу багийн үйл ажиллагаанаас оруулсан орлогоос багт ногдох хэсгийг захиран зарцуулах
- 4.5. Профессорын үүрэг:
- 4.5.1. Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, судалгааны ажлын санхүүжилтийг тасралтгүй бүрдүүлэх;
- 4.5.2. Багийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, өөрийн багийн сургалт, судалгааны ажлын чанар, үр дүнг бүрэн хариуцах;
- 4.5.3. Их сургуульд сургалт-эрдэм шинжилгээ-инновацийн үйл ажиллагаанаас орлого оруулах
- 4.5.4. СПБ-ийн үйл ажиллагааны талаар ШУТИС, бүрэлдэхүүн сургууль, холбогдох салбарын хуралд тайлагнах

#### ТАВ. СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГИЙН ЛАБОРАТОРИЙН БААЗ

- 5.1. Хэд хэдэн судалгааны профессорын баг, салбар хамтарч дундын судалгааны лаборатори, төв, байгуулан ажиллаж болно.
- 5.2. Судалгааны лабораторийг үүсгэн байгуулсан эрдэмтний болон ивээн тэтгэгчийн нэрээр нэрлэж болно. Лабораторийн олон улсын жишигт нийцсэн эрдэм шинжилгээ судалгааны талбарын ангилал дахь нэршлийг тусгасан байна.
- 5.3. СПБ нь гадаадын их, дээд сургууль, хүрээлэн, төв, үйлдвэр аж ахуйн газруудтай хамтран судалгааны лаборатори байгуулан ажиллуулж болно.
- 5.4. Судалгааны лаборатори нь СПБ-ийн хүний нөөц, технологийн чадавх, хөрөнгө, санхүүгийн нөөц, эх үүсвэрээс шалтгаалан хаалттай ба нээлттэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

#### ЗУРГАА. СУДАЛГААНЫ ПРОФЕССОРЫН БАГИЙН ТӨСӨВ БҮРДҮҮЛЭЛТ

- 6.1. СПБ нь үйл ажиллагаагаа өөрийн орлогоор санхүүжүүлэх зарчмыг баримтлан түшиглэсэн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн санхүүгийн дансыг ашиглан ажиллана.
- 6.2. СПБ нь тухайн жилийн орлого, зардлын төсвөө түшиглэсэн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн удирдлагатай зөвшилцөн, батлуулж мөрдөнө.
- 6.3. СПБ-ийн төсөв нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 6.3.1. Төсөл, гэрээт ажил;
- 6.3.2. Инновацийн болон туршилт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа;
- 6.3.3. Магистр, докторын болон мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт;
- 6.3.4. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, экспертизийн үйл ажиллагаа;
- 6.3.5. Эрдэм шинжилгээний бусад үйл ажиллагаа, арга хэмжээ;
- 6.3.6. Мэдлэгийн өв буюу оюуны өмч, технологи дамжуулалт;
- 6.3.7. Гадаад дотоодын байгууллага, хувь хүний хөрөнгө оруулалт, хандив, тусламж
- 6.3.8. Судалгааны санхүүжилт
- 6.3.9. Улсын төсвийн санхүүжилт

- 6.3.10. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр
- 6.4. СПБ-ийн үйл ажиллагааг дараах хэлбэрээр санхүүжүүлж болно. Үүнд:
  - 6.4.1. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт
  - 6.4.2. Буцалтгүй санхүүжилт
  - 6.4.3. Судалгаа ба инновацийн грант
- 6.5. Тухайн СПБ-т туршилт судалгааны ажил гүйцэтгэж байгаа доктор оюутны туршилт судалгааны ажлын кредитийн төлбөрийн 60 хүртэлх хувийг тухайн доктор оюутны лабораторийн туршилтын ажилд зарцуулна.
- 6.6. Шинээр байгуулагдаж буй профессорын багт эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийг нэг удаа бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны төсвөөс Захирлын зөвлөлийн шийдвэрээр олгож болно.
- 6.7. Шинээр байгуулагдаж буй профессорын багийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор эхний жилийн ШУТИС-ийн Технологийн сан, бүрэлдэхүүн сургуульд оруулах төслийн шимтгэлийг тус бүр 3 хувь байхаар тооцно.
- 6.8. Тухайн СПБ-ийн эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн шимтгэлээс бүрэлдэхүүн сургуульд үүссэн хуримтлалын 60 хүртэлх хувийг багт судалгааны тоног төхөөрөмж худалдан авах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцох, мэргэжил дээшлүүлэх зорилгоор олгоно.
- 6.9. СПБ-ийн өмчид мэдлэгийн өв буюу зохиогчийн эрх, патент зэрэг ашиг орлого авчрах оюуны өмч, барааны тэмдэг хамарагдана.
- 6.10. СПБ байгуулагдсанаар эрдэм судлалын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулан, бүтээмж нэмэгдсэнээр инновацийн нөөцийг өсгөж, энтерпренер хэв шинж бүхий судалгааны их сургуулийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ДОЛОО. БУСАД

- 7.1. СПБ нь албан хэрэг хөтлөхдөө түшиглэсэн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн хэвлэмэл хуудас, тэмдэгийг ашиглана.
- 7.2. СПБ-ийг татан буулгах асуудлыг багийн гишүүдийн санал, түшиглэсэн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн шийдвэр зэргийг үндэслэн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 7.3. Энэ журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай холбогдох дэд зөвлөлөөс гаргах ба Ректорын зөвлөлийн хурал, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Ректорын тушаалаар батална.